

БАТЛАВ:

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ч.САЙХАНБАЯР

2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ,
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Төсөв, эх үүсвэр (мян.төг)	Хариуцах нэгж, ажилтны нэр	Хугацаа /сар, улирал/
	1	2	3	4	5
1	Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг үндэслэн төрийн жинхэнэ албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх; төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, ур чадварын	Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн хэрэгжилт хангагдаж, төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдэнэ.	-	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс Н.Золжаргал	I улиралд

	нэмэгдлийг шийдвэрлүүлэх				
2	Албан хаагчдын ажлын үр дүн, гүйцэтгэлийг дүгнэн, хагас, бүтэн жилээр урамшуулал олгох	Төрийн албан хаагчдын нэмэгдэл баталгаа хангагдана.		Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс	6, 12 дугаар сард
3	Хүүхдийн баяр, Шинэ жилийн баяраар албан хаагчдын 0-16 насны хүүхдүүд, гэр бүлд бэлэг гардуулах ажлыг зохион байгуулах	Албан хаагчдын гэр бүл, 0-16 насны хүүхдүүд бүрэн хамрагдсан байна.	2,6 сая	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс	6, 12 дугаар сард
4	Албан хаагчдын хүсэлт, ажлын шаардлагаар: <ul style="list-style-type: none"> ✓ Компьютер; ✓ принтер; ✓ зөөврийн компьютер; ✓ сандал; ✓ диктафон; ✓ канон; ✓ лазер метр. 	Ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоог бүрэн хангаж, ажлын бүтээмж сайжирна.	судалгаагаар	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс, Өмч хамгаалах байнгын зөвлөл	II, III улиралд
5	Үйлчилгээний ажилтнуудыг хөдөлмөрийн багаж хэрэгсэл, ажлын хувцсаар хангах	Ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоог бүрэн хангаж, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэнэ.	500.0 мян	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс, ХАБ-ын ажилтан	III улиралд

6	Үйлчилгээний ажилчдад Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын сургалт зохион байгуулах	Ажлын байрны аюулгүй ажиллагаа хангагдана.		ХАБ ажилтан	II улиралд
7	Албан хаагчийн ар гэрт гачигдал тохиолдох, хүндээр өвдөж, урт хугацааны турш ажил хөдөлмөрийн чадвараа түр алдсан тохиолдолд тусламж, дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх	Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа сайжирна.	7,0-8,0 сая	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс	Жилдээ
8	Галлагаатай гэр байшинд амьдардаг ажилтан, албан хаагчдын өвөлжилтийн бэлтгэлд зориулан сайжруулсан шахмал түлш худалдан авахад дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх	Ажилтан, албан хаагчдын амьжиргаанд дэмжлэг үзүүлнэ.	2,5 сая	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс	IV улиралд
9	Хөдөлмөрийн болон нийгмийн идэвхийг өрнүүлэхэд чиглэсэн чөлөөт цаг, амралтыг зөв зохистой өнгөрүүлэх талаар тодорхой ажлууд зохион байгуулах	Ажилтан, албан хаагчдын хамт олонч, эерэг уур амьсгал бүрдэн, багаар ажиллах чадвар сайжирна.		ЗТСХ, ӨМХ, ӨБМХ, ӨХАДАХ	Жилийн турш
10	Ажлын байрны эрүүл ахуй, эрүүл мэндийн анхан шатны тусламжийн багаж хэрэгсэл, эм бэлдмэлээр тогтмол хангах	Ажиллах таатай нөхцөл бололцоо хангагдана.	500.0 мян	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс, ХАБ ажилтан	Жилийн турш


11	Ажил үүргээ идэвх зүтгэл, үр дүнтэй биелүүлж, өндөр амжилт гаргасан албан хаагчдыг шагнал урамшуулалд тодорхойлох	Ажилтан, албан хаагчдын ажиллах урам зориг, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэнэ.	-	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс	III, IV улиралд
12	Байгууллагын албан хаагчдыг хөнгөлөлттэй нөхцлөөр орон сууцанд хамруулах үйл ажиллагааг эхлүүлэх	Амьдрах нөхцөл сайжирч, нийгмийн асуудал шийдэгдэнэ.	-	Удирдлагын зөвлөл	Жилдээ
Нийт					


Хянасан:

ЗТСХ-ийн дарга

Боловсруулсан:

ЗТСХ-ийн ахлах, хүний нөөцийн мэргэжилтэн


М.Мөнхбаяр


Н.Золжаргал